



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ШИНЭ ХАРХОРУМ ХОТЫН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЛСАН
ЗАХИРГАА



ЭРТНИЙ НИЙСЛЭЛ

ХАРХОРУМ

ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ОЛОН УЛСЫН
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

2024 он

**“ШИНЭ ХАРХОРУМ” ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /КОНЦЕПЦ/ БОЛОВСРУУЛАХ ОЛОН УЛСЫН
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УДИРДАМЖ**



01 **ЕРӨНХИЙ АГУУЛГА**

ОРШИЛ
ЗОРИЛГО
ХУГАЦАА

02 **ХАМРАХ ХҮРЭЭ, БҮРТГЭЛ ҮҮСГЭХ,
ОРОЛЦОХ ЭРХ АВАХ**

ОРОЛЦОГЧИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОРОЛЦОХ ХЭЛБЭР
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ДҮГНЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН
БҮРТГҮҮЛЭХ, ОРОЛЦОХ ЭРХ АВАХ

03 **МАТЕРИАЛД ТАВИГДАХ
ШААРДЛАГА**

МАТЕРИАЛЫН БҮРДЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА
МАТЕРИАЛ ИРҮҮЛЭХ, ШААРДЛАГА
ЗОХИОГЧИЙН ЭРХ

04 **ШАЛГАРУУЛАЛТ,
ТӨЛБӨР**

ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ
ШАЛГАРУУЛАЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ТӨЛБӨР ОЛГОХ ЗАРЧИМ

05 **БУСАД НӨХЦӨЛ**

АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС
МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Та “Линк” болон “Энд дарна үү”
тэмдэг дээр дарж бусад дэлгэрэнгүй
мэдээлэл татаж авна уу.

01

ОРШИЛ



“Орхоны хөндийн нутаг дэвсгэр нь эртний төрт улс болох Хүннү гүрний Луут хотоос эхлэн, Жужаны Мумо хот, Уйгурын Хар балгас, Түрэгийн хаад, ноёдын тахилын онгон, Их Монгол улсын Хархорум хот байрлаж байсан манай улсын түүх, соёл, төрт ёсны голомт нутаг юм. Эзэн Чингис хаан их ор суусны XV он,

цагаан луу жил буюу 1220 онд Их Монгол Улсын нийслэл “Хархорум” хотыг Монгол түмний ариун гал голомт, Орхон голын удам хөндийд байгуулах зарлиг буулгаж их хот байгуулах ажлыг эхлүүлсэн. Хархорум хотыг цогцлоон хөгжүүлэх үйл хэргийг Өгэдэй хаан нэр төртэй үргэлжлүүлж, Гүюг, Мөнх хааны үед хотын суу алдар дэлхий даяар түгэн манджээ. Хархорум хот нь олон газрын эрдэмтэн мэргэд, уран бүтээлчид, гар урчууд, худалдаачид, орон орны хаад язгууртны элч төлөөлөгч нар аж төрж, морилон саатдаг дэлхийн улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн төв байсан юм.

”

“Монгол улсын нийт газар нутгийн 0,3% эзэлдэг Улаанбаатар хотод хүн амын 50% орчим амьдарч байгаа бөгөөд цаашид ч өсөн нэмэгдэх хандлагатай байна. Нийгэм, эдийн засаг, хүн

амын хэт төвлөрөлөөс үүдэлтэй асуудлууд хуримтлагдсаар гамшгийн эрсдлийн түвшин өндөрсөж байгаа нь шинэ хот байгуулах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

”

ЗОРИЛГО

“Шинэ Хархорум” хотын алсын хараа, хөгжлийн тэргүүлэх чиглэл, хот төлөвлөлтийн зарчим, хотын дүр төрхийг тодорхойлох.

ХАРХОРУМ ХОТ



ЭНД ДАРЖ БАЙРШЛЫГ
ХАРНА УУ

ХУГАЦАА

2024.03.18 - - 2024.08.02

03.18

БҮРТГЭЛ ЭХЛЭХ
ХУГАЦАА

04.15

БҮРТГЭЛ ХААГДАХ
ХУГАЦАА
/ 12:00 ЦАГ /

04.15-07.16

ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
БОЛОВСРУУЛАХ ХУГАЦАА

04.22-05.21

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ
ДУНГАХ КОМИССЫН ГИШҮҮДИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХУГАЦАА

07.25-
-07.31

ОЛОН НИЙТЭС
ҮНЭЛГЭЭ АВАХ ХУГАЦАА

07.25-
-07.31

БҮТЭЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН
ГАРГАХ ХУГАЦАА

07.19

I ШАТНЫ ҮНЭЛГЭЭ
ЕРӨНХИЙ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ
/ 12:00 ЦАГ /

07.16

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ
ЭЦСИЙН ХУГАЦАА
/ 12:00 ЦАГ /

07.30-
-07.31

БҮТЭЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА, ИЛТГЭЛ
ТАВИХ ХУГАЦАА

07.31

II ШАТНЫ ҮНЭЛГЭЭ
ОЛОН НИЙТИЙН ҮНЭЛГЭЭ
ГАРГАХ ЭЦСИЙН
ХУГАЦАА

08.01

III ШАТНЫ ҮНЭЛГЭЭ
КОМИССЫН ГИШҮҮДИЙН
ҮНЭЛГЭЭ ГАРГАХ
ХУГАЦАА

08.02

ШИЛДЭГ ОРОЛЦОГЧДЫГ
ЗАРЛАХ ХУГАЦАА

ДЭЭРХ ЦАГИЙН ХУВААРИЙГ УТС-8 / ULAANBAATAR CITY /
ЦАГИЙН БҮСЭЭР ТООЦНО.

УМ ХОТ ХАРХОРОМ ХОТ ХАРХО

- Албан ёсны хэл нь **Монгол** болон **Англи** хэл байна.
- Дотоодын болон гадаадын байгууллага, баг, хувь хүнд нээлттэй.
- Оролцогч нь мэргэжлийн чиглэлийн **9**-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй баг болон байгууллага байх бөгөөд доорх мэргэжлийн чиглэлүүдээс бүрдсэн байна.

Хот төлөвлөгч

Архитектор

Авто зам, гүүрийн инженер

Ландшафтын архитектор

Хот төлөвлөлтийн эдийн засагч

Дэд бүтцийн инженер

Бусад /шаардлагатай бусад мэргэжилтнүүдийг нэмэх боломжтой/

- Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаадын болон дотоодын зураг төслийн мэргэжлийн байгууллага, хувь хүнтэй хамтран оролцож болно.
- Оролцож байгаа байгууллага болон хувь хүмүүс өөр байгууллага, багт давхардан оролцох боломжгүй.
- Бүртгэлийн хугацаа дуусах хүртэл хамтран оролцогч **нэмэх, хасах, солих** боломжтой.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ДҮГНЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

НИЙТ **15** ХҮН

- Сонгон шалгаруулалтыг дүгнэх комиссын бүрэлдэхүүнд Монгол улсаас

13 ХҮН

- Олон улсын хот төлөвлөгч, архитекторуудын төлөөллөөс

2 ХҮН

/Комиссын бүрэлдэхүүнд орох 6 гишүүнийг сонгон шалгаруулалтаар авна/

■ БҮРТГҮҮЛЭХ, ОРОЛЦОХ ЭРХ АВАХ

- Оролцогч <https://competition.kharkhorum.gov.mn/> уралдааны цахим хуудсаар орж бүртгэл үүсгэх бөгөөд бүртгүүлсэн дарааллаар багийн дугаар үүснэ. Цаашид олон нийтээс санал авах, дүгнэх үйл ажиллагаанд багийн дугаарыг хэрэглэнэ.
- Үзэл баримтлал боловсруулахад шаардлагатай суурь материалын төлбөр болох 999,000 төгрөг төлсөн оролцогчдод **24 цагийн дотор** нэвтрэх нэр, нууц үгийг анх бүртгүүлсэн и-мэйлээр хүргүүлж сонгон шалгаруулалтад оролцох албан ёсны эрхийг баталгаажуулна. Төлбөрийг бүх банкны **виза карт** болон **socialpay** ашиглан төлөх боломжтой. / **төлбөрийг буцаан олгох боломжгүй.**/
- Сонгон шалгаруулалтад оролцох албан ёсны эрх авсан оролцогчид өөрийн эрхээр нэвтрэх дараах материалыг татаж авна. Эрх нь баталгаажсан өдрөөс эхлэн үзэл баримтлалыг боловсруулж эхлэх боломжтой.

Материалын нэр	Файлын төрөл	Хэл
Сонгон шалгаруулалтын удирдамж		
"Шинэ Хархорум" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал / концепц/ боловсруулах даалгавар	*.pdf	Монгол, Англи хэл
Засаг захиргааны хил хязгаарын мэдээлэл /Архангай, Өвөрхангай аймгийн хил, Хархорин, Хашаат, Өгжинуур сумдын хил, Төлөвлөлтийн талбайн хил/	*.dwg *.shp	
Байр зүйн мэдээлэл	*.shp *.dwg *.tif *.jpg	
Дэд бүтцийн мэдээлэл		
Газар хөдлөлтийн мэдээлэл	*.shp *.dwg	
Түүх, археологи, соёлын дурсгалт газрын мэдээлэл	*.dwg	Монгол, Англи хэл
"Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанаас гаргасан төлөвлөлтийн урьдчилсан шийдэл	*.shp *.dwg *.pdf	
Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллагын жагсаалт	*.pdf	

Оролцогчдод өгсөн мэдээлэл, баримт бичиг нь "Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны өмч хэвээр байх бөгөөд зөвхөн уралдааны хүрээнд ашиглах боломжтой.

Сонгон шалгаруулалтад оролцох эрх авсан
бүх оролцогч дараах материалын бүрдлийг
ирүүлнэ.

01 ТАЙЛБАР БИЧИГ

30x30 см хэмжээтэй

Ажлын файл: *.doc, *.xlsx;
Эцсийн файл: *.pdf;

02 ЗУРАГЛАЛЫН МАТЕРИАЛ

30x30 см хэмжээтэй

Ажлын файл: *.dwg, *.shp, *.skp, *.ls, *.max;
Эцсийн файл: *.pdf, *.jpg;

03 ЗУРАГЛАЛЫН САМБАР

Цахим хуудсанд байрлуулах болон үзэсгэлэнд
зориулсан самбарын зураглал дээр оролцогч
баг, байгууллагын лого, нэрийг тавихгүй байх.

ЦАХИМ ХУУДСАНД БАЙРЛУУЛАХ

30x30 см хэмжээтэй, 10–15 ширхэг

Ажлын файл: *.psd, *.cdr, *.indd, *.ai, *.eps;
Эцсийн файл: *.pdf, *.jpg;

ҮЗЭСГЭЛЭНД ЗОРИУЛСАН САМБАР

170x120 см хэмжээтэй, 5 ширхэг
100x80 см хэмжээтэй, 2 ширхэг

Ажлын файл: *.psd, *.cdr, *.indd, *.ai, *.eps;
Эцсийн файл: *.pdf, *.jpg;

04 ВИДЕО ТАНИЛЦУУЛГА

5–10 минут

*.mp4, 1080HD;

05 БУСАД ТАНИЛЦУУЛГА

Төрөл хэмжээ
нээлттэй;

06

Оролцогч баг болон байгууллагын
өмнө хийж гүйцэтгэсэн ижил
төгстэй зураг төслийн ажлын
талаарх мэдээлэл.

*.pdf;

07

Оролцогч баг болон байгууллагын
удирдагч, голлох мэргэжилтэн тус
бүрийн ур чадвар болон
туршлагын талаарх мэдээлэл.

*.pdf;

1 үе шатанд тэнцсэн оролцогчид
сонгон шалгаруулалтыг дүгнэх
комиссын гишүүдэд танилцуулах

2x1 хэмжээтэй Танилцуулга
/ *.pptx/ ирүүлнэ.



МАТЕРИАЛ ИРҮҮЛЭХ, ШААРДЛАГА

- Оролцогчид өөрийн бүртгэл болон цахим шуудан, утсаар дамжуулан нэмэлт тодруулга, мэдээлэл авах боломжтой бөгөөд анх бүртгүүлсэн и-мэйл, утсаар хариу хүргүүлнэ; **/цагийн зөрүүнээс шалтгаалан 24-48 цагийн дотор хариу өгөхийг анхаарна уу/**
- Оролцогчид зөвхөн нэг бүтээл ирүүлэх бөгөөд өөрийн бүртгэлээр дамжуулан материалаа сонгон шалгаруулалтын цахим хуудсанд байршуулна;
- Оролцогчид бүх материалаа хугацаандаа багтааж байршуулах бөгөөд нөөц хугацаа төлөвлөх шаардлагатай; /файл удаан унших, интернэт гацах гэх мэт эрсдэлээс сэргийлэх/
- Материал хүлээн авах хугацаанаас хойш ирүүлсэн файлуудыг хүлээн авахгүй;
- Хугацаандаа амжиж ирүүлсэн материалуудыг хүлээн авсан тухай баталгаажуулах мэдээллийг зохион байгуулагч талаас хүргүүлнэ;
- Монгол улсад ирж өөрийн бүтээлээ танилцуулах оролцогчдын төлөөлөл **1-2 хүний** мэдээллийг өөрийн бүртгэл болон цахим шуудангаар дамжуулан **2024.05.20-ны** өдрийн дотор ирүүлсэн байна.
- Материалыг Монгол эсвэл Англи хэл дээр ирүүлнэ /Сонголтоор/.

ЗОХИОГЧИЙН ЭРХ

- Шилдгээр шалгарсан эхний 5 баг, байгууллагын бүтээлүүдийн **зохиогчийн эрх** нь оролцогчийн талд үлдэх ба цаашид ашиглах, өөрчлөх, шинэчлэх, хөгжүүлэх онцгой эрх захиалагч байгууллагад хадгалагдана.
- Шилдгээр шалгарсан эхний 5 баг, байгууллагын ирүүлсэн **материал** нь цаашид зохион байгуулагч талын өмч болох бөгөөд буцааж олгохгүй архивын баримт болж хадгалагдана.
- Шилдгээр шалгарсан баг, байгууллагын төлөөллийг "Шинэ Хархорум" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд оролцуулна.

Сонгон шалгаруулалтыг 3 үе шаттай явуулах бөгөөд 1-р шатанд тэнцсэн оролцогчид дараагийн шатанд оролцох эрхтэй болно. 3 үе шатны үнэлгээний нэгдсэн нийлбэрээр хамгийн өндөр оноотой эхний 5 байрыг шалгаруулна.

01 ҮЕ ШАТНЫ ҮНЭЛГЭЭ

УРЬДЧИЛСАН ШАЛГАРУУЛАЛТ, ЕРӨНХИЙ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

"Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанаас уралдаанд оролцогчдын ерөнхий чадварыг үнэлнэ.

02 ҮЕ ШАТНЫ ҮНЭЛГЭЭ

ОЛОН НИЙТИЙН ҮНЭЛГЭЭ

- 0 I үе шатанд тэнцсэн оролцогчдын бүтээлийг цахим сүлжээгээр дамжуулан иргэд, олон нийтийн үнэлгээг авна.
- 0 I үе шатанд тэнцсэн оролцогчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж иргэд, олон нийтийн үнэлгээг авна.

03 ҮЕ ШАТНЫ ҮНЭЛГЭЭ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ДҮГНЭХ КОМИССЫН ҮНЭЛГЭЭ

- 0 I үе шатанд тэнцсэн оролцогчдын төлөөлөл / 1-2 хүн / өөрсдийн бүтээлийг сонгон шалгаруулалт зохион байгуулж буй газарт ирж сонгон шалгаруулалт дүгнэх комиссын гишүүдэд танилцуулна. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд цахимаар танилцуулга хийх боломжтой. Танилцуулга 30 минутаас хэтрэхгүй байх.
- 0 Сонгон шалгаруулалтыг дүгнэх комиссын гишүүд оролцогчдын бүтээлд үнэлгээ өгнө.

ШАЛГАРУУЛАЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

01 ЕРӨНХИЙ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанаас оролцогчдын ирүүлсэн материалын суурь оноог өгнө. Энэ шатанд 20 ба түүнээс дээш оноо авсан оролцогчид дараагийн шатанд оролцох эрхтэй болно.

1.1 Ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал

1.2 Баримт бичгийн бүрдэл, техникийн гүйцэтгэл

1.3 Оролцогч баг болон байгууллагын өмнө хийж гүйцэтгэсэн ижил төстэй зураг төслийн ажлын туршлага

1.4 Оролцогч баг болон байгууллагын удирдагч, голлох мэргэжилтэн тус бүрийн үр чадвар болон туршлага

02 олон нийтийн үнэлгээ

2.1 “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны цахим сүлжээнд ирүүлсэн олон нийтийн үнэлгээ

2.2 Үзэсгэлэнгийн үеэр ирүүлсэн олон нийтийн үнэлгээ

03 сонгон шалгаруулалтыг дүгнэх комиссын үнэлгээ

Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгон шалгаруулалтыг дүгнэх комиссын хурлаар батална.

Нийт 34 оноо

26 оноо

6 оноо

1 оноо

1 оноо

Нийт 6 оноо

3 оноо

3 оноо

60 оноо

Нийт 100 оноо



ТӨСВИЙН БАГЦ

1,600,000,000 ₮



ТЭРГҮҮН БАЙР НЭГ ОРОЛЦОГЧ
750,000,000 ₮




ДЭД БАЙР НЭГ ОРОЛЦОГЧ
400,000,000 ₮



ГУТГААР БАЙР НЭГ ОРОЛЦОГЧ
200,000,000 ₮



ДӨРӨВДҮГЭЭР БАЙР НЭГ ОРОЛЦОГЧ
150,000,000 ₮



ТАВДУГААР БАЙР НЭГ ОРОЛЦОГЧ
100,000,000 ₮

- I үе шатанд тэнцсэн гадаадын болон хөдөө орон нутгийн оролцогчдын төлөөлөл / 1–2 хүн / –ийг Улаанбаатар хотод байрлах 3 хоногийн зочид буудлын зардлыг зохион байгуулагч тал хариуцна.
- Бусад зардлыг оролцогчид өөрсдөө хариуцна.

Дээрх үнийн дүнд нэмэгдсэн өртгийн албан татварын дүн орсон болно /10% суутган олгоно/. Оролцогчид бусад татвартай холбоотой асуудлыг өөрсдөө хариуцана.

- Оюуны өмчөөр хамгаалагдсан зохиогчийн эрхтэй бүтээл хуулбарлаагүй мэргэжлийн ёс зүйтэй байх /оюуны өмч зөрчсөн нь батлагдсан тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох эрхийг хасна/;
- Оролцогчид бусад этгээдийн судалгааны материал, мэдээллийг ашигласан тохиолдолд эх сурвалжаа дурдсан байх;
- Сонгон шалгаруулалтын үеэр вэб сайтын доголдол, утасны сүлжээ, сервер, компьютерын тоног төхөөрөмж, программ хангамжийн доголдол, техникийн доголдол, цахим сүлжээнд гэмтэл гарсан тохиолдолд зохион байгуулагч тал хариуцлага хүлээхгүй;
- Сонгон шалгаруулалт зохион байгуулагч нь цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой аливаа нэмэлт өөрчлөлт, тодруулгыг хийх эрхтэй бөгөөд энэ тухай оролцогчдод мэдэгдэнэ;
- Оролцогч нь вэбсайт, цахим хуудсыг зориудаар гэмтээх, өөрчлөх оролдлого хийх, автомат төхөөрөмж ашиглах, хакердах, удирдамжид заасан нөхцөлийг зөрчих, зохион байгуулагчаас тавьсан аливаа шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд сонгон шалгаруулалтын оролцох эрхийг хасна;
- Оролцогч нь сонгон шалгаруулалтын даалгавар, удирдамжийг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд зохион байгуулагчийн зүгээс гаргасан аливаа шийдвэр эцсийн байх тул давж заалдах эрхгүй.

Оролцогчид зохион байгуулагч талд зөвхөн дараах асуудлын хүрээнд гомдол гаргах болох бөгөөд бусад асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авч хэлэлцэхгүй.

- Зохиогчийн эрх зөрчигдсөн асуудлаар /Хувь хүн болон байгууллагын бүтээлийг хуулбарлах оролцсон/;
- Сонгон шалгаруулалтыг дүгнэх комиссын бүрэлдэхүүнд багтсан гишүүнтэй оролцогчид ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн тохиолдолд;

Гомдлыг нэгдсэн үнэлгээ гаргах хугацаанаас 1-ээс доошгүй хоногийн өмнө бичгээр болон өөрийн бүртгэлээр дамжуулан зохион байгуулагч талд ирүүлнэ. Хугацаа хоцорсон болон баримт нотолгоонд үндэслээгүй гомдлыг хүлээж авахгүй.



ХОЛБОО БАРИХ



“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Юнескогийн гудамж, Далай тауэр, 11 давхар

Утас: 976 – 77711220

Вэб сайт: <http://kharkhorum.gov.mn/>



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ



ШИНЭ ХАРХОРУМ ХОТЫН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ЗАХИГЧЛАА

ХАРХОРУМ ХОТ



УРАЛДААН БҮРТГҮҮЛЭХ

www.competition.kharkhorum.gov.mn

